



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН
ДААТГАЛЫН ТӨСӨЛ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

МАЛЫН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛЫН 2013 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

УЛААНБААТАР ХОТ
2013 он



Агуулга

1. Малын эрсдэлийн даатгал/МЭД/-ын 2013 оны борлуулалтын улиралд хийж гүйцэтгэсэн ажлуудын жагсаалт	3
2. МЭД-ын 2013 оны борлуулалт	5
2.1 МЭД-ын борлуулалтын үр дүн	5
2.2 МЭД-ын бүлгийн даатгал.....	9
2.3 МЭД-ын хураамжийн зээл, хөнгөлөлттэй зээл	9
3. Даатгалын компанийн борлуулалтын үр дүн.....	11
Дүгнэлт.....	15



Хүснэгт, графикийн товчоо

<i>Хүснэгт №1. МЭД-ын 2013 борлуулалтын улирлын үйл явц</i>	3
<i>Хүснэгт №2. МЭД-д даатгуулсан малчин өрхийн тоо, даатгуулсан малын нийт үнэлгээ, хураамжийн хэмжээ, 2013 он</i>	6
<i>Хүснэгт №3. МЭД-д хамрагдсан малын тоо (малын төрөл, аймгаар)</i>	7
<i>Хүснэгт №4. Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалтын тоо, хураамжийн орлого болон нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн (2013 он, аймгаар)</i>	8
<i>Хүснэгт №5. Хураамжийн зээл авсан малчдын тоо, зээлийн хэмжээ</i>	9
<i>Хүснэгт №6. 2013 онд олгосон хөнгөлөлттэй зээлийн хэмжээ болон зээлдэгчийн тоо</i>	10
<i>Хүснэгт №7. Даатгалын компаниудын борлуулалтын тоо (аймгаар, 2013 он)</i>	11
<i>Хүснэгт №8. Даатгалын компаниудын МЭД-ын хураамжийн орлого (аймгаар, 2013 он)</i>	12
<i>Хүснэгт №9. Даатгуулсан малчин өрхийн тоо ба хураамжийн орлогын 2012 оны борлуулалттай харьцуулсан дүн (даатгалын компаниар)</i>	13
<i>График №1. МЭД-ын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо</i>	5
<i>График №2. МЭД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого</i>	6
<i>График №3. Аймгийн малчин өрхөд МЭД-д даатгуулсан малчин өрхийн эзлэх хувь</i>	7
<i>График №4. Хөнгөлөлттэй зээлийн хэмжээ болон хөнгөлөлтийн хэмжээ</i>	10
<i>График №5. Даатгалын компаниудын хураамжийн орлого, дүнд эзлэх хувиар</i>	12
<i>График №6. Борлуулалт хийсэн болон борлуулалт хийгээгүй даатгалын төлөөлөгчдийн тоо (даатгалын компаниар)</i>	13



I. МЭД-ын 2013 оны борлуулалтын улиралд хийж гүйцэтгэсэн ажлуудын жагсаалт

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан МИДТ-ийн “Хөгжлийн зээлийн шинэчилсэн хэлэлцээр”, “Төсөл хэрэгжүүлэх заавар”, ажлын төлөвлөгөөний дагуу МЭД-ын 2013 оны борлуулалтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Хүснэгт №1. МЭД-ын 2013 борлуулалтын улирлын үйл явц

Огноо	Үйл ажиллагаа
2012 оны 9-12-р сар	<ul style="list-style-type: none"> МЭД-ын 2013 оны борлуулалтын улиралд хийх өөрчлөлтүүдийг тодорхойлсон. МИД төслийн програм хангамжийн 2013 оны хувилбарыг боловсруулж эхэлсэн. МЭД-ын 2013 оны борлуулалтын улиралд оролцох даатгалын компаниудыг сонгон шалгаруулж, 2012 оны борлуулалтын улиралд оролцсон “Бодь даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК-иуд үргэлжлүүлэн оролцохоор болж, нэмэгдэж “Номин даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК-иуд оролцохоор болсон. 2013 оны борлуулалтын төлөвлөгөөг боловсруулсан. МИД-ын програм хангамжийн 2012 оны хувилбарыг хаан, 2012 оны борлуулалтын мэдээллийн санг битүүмжилсэн. “Бодь даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК-уудын МИД-ын тэргүүний даатгалын төлөөлөгчдийн дунд туршлага солилцох уулзалтыг зохион байгуулсан. МЭД-ын 2012 оны нөөцийн сангуудад хүү тооцох гэрээг Төрийн банк болон Голомт банктай байгуулсан.
2013 оны 1-2-р сар	<ul style="list-style-type: none"> МЭД-ын зарчим, үйл ажиллагааны талаарх даатгалын компанийн сургагч багш, сумдын ажилтнууд, даатгалын төлөөлөгчид, орон нутгийн удирдлагуудад зориулсан гарын авлагын мэдээллийг шинэчлэн боловсруулсан. “Малын эрсдэлийн даатгал”, “Даатгалын төлөөлөгчийн гарын авлага”-ыг боловсруулж, даатгалын төлөөлөгч болон оролцогч талуудад тараасан. 2012 онд МЭД-д хамрагдсан малчдад зориулсан 2013 оны цаг тооны бичгийг бэлтгэж хэвлэн малчдад тараасан. Малчдын бүлгийн малыг даатгалд хамруулах “Бүлгийн малын эрсдэлийн даатгал” бүтээгдэхүүний судалгаа хийгдэж эхэлсэн.
3-р сар	<ul style="list-style-type: none"> 2013 оны борлуулалтын улиралд ашиглах МЭД-ын хураамжийн хувийг тодорхойлсон. МЭД-ын гэрээг шинэчлэн боловсруулсан. МЭД-ын 2013 оны борлуулалтын улиралд ашиглагдах даатгалын баталгааны загварыг боловсруулан хэвлүүлж, даатгалын компаниудад хүлээлгэн өгсөн. МЭД-ын болон ердийн даатгалын төлөөлөгчид эрх олгох шалгалтыг ТХН, СЗХ-той хамтран зохион байгуулж, СЗХ даатгалын төлөөлөгчийн эрхийг олгосон. Нийт 2252 даатгалын төлөөлөгч 2013 оны МЭД-ын борлуулалтын улиралд ажиллахаар болсон. Даатгалын компанийн сургагч багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан. Малчдын бүлгийн малыг даатгах “Бүлгийн малын эрсдэлийн даатгал” бүтээгдэхүүнийг туршилтаар журмаар Завхан аймгийн 6 суманд хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, бүлгийн даатгалын гэрээ, баталгаа, хураамжийн хувийг боловсруулсан.



4-р сар	<ul style="list-style-type: none">• МЭД-ын 2013 оны борлуулалтын улирал эхэлсэн.• Зурагт хуудас, нугалбар, даатгагчдад зориулсан товхимол, сонин зэрэг хэвлэмэл сурталчилгааны материалуудыг хэвлэж тараасан.• МЭД-д хамрагдах хүсэлтэй малчдыг богино хугацаанд, түргэн шуурхай хамрагдах боломжийг олгох, даатгалын төлөөлөгчдийн борлуулалтын зардлыг хэмнэх зорилгоор даатгалд хамрагдах хүсэлтэй малчдын санал хүсэлтийг 9100-0770, 9807-0770 утсаар авч, ТХН-ийн аймгийн салбарууд, даатгалын төлөөлөгчдөд мэдэгдэж, борлуулалтыг эрчимжүүлсэн.• МИД-ын програм хангамжийн 2013 оны хувилбарыг шалгаж, хүлээн авсан.• МЭД-ын 2013 оны борлуулалтын улирлыг идэвхижүүлэх, борлуулалтын мэдээллийг чанаржуулах, борлуулалтын явцад ТХН-ийн зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор долоо хоног тутамд борлуулалтын мэдээг явуулж байхыг ТХН-ийн аймгийн салбаруудад үүрэг болгож, борлуулалтын мэдээг оролцогч талуудад цаг тухай бүр бэлтгэн хүргүүлж, мэдээг авч эхэлсэн.
5-р сар	<ul style="list-style-type: none">• Оролцогч даатгалын компаниудтай МИД-ын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан.• МЭД-ын 2013 оны борлуулалтанд оролцогч даатгалын компаниуд МИД-д оролцогчийн хураамжийг Дундын дансанд байршуулсан.• МЭД-ын борлуулалтыг бүртгэх програм хангамжийг 21 аймгийн даатгалын компанийн салбар болон ТХН-ийн аймгийн салбаруудад суурилуулж, програм хангамжийн сургалтыг зохион байгуулсан.• Сумдын удирдлагууд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор сумдын ЗДОрологч болон МЭҮТМААҮТҮБХМэргэжилтнүүдэд МИД-ын тухай сургалтыг зохион байгуулсан.• МЭД-ын 2013 оны борлуулалтыг идэвхижүүлэх, борлуулалтын явцад хяналт тавих зорилгоор ТХН-ийн зүгээс аймгийн салбарыг сумдуудад ажиллуулсан.
6-р сар	<ul style="list-style-type: none">• ҮСХ-той хамтран хагас жилийн мал тооллогыг түүвэр судалгааны аргаар төсөл хэрэгжиж байгаа 21 аймагт зохион байгуулсан.
7-р сар	<ul style="list-style-type: none">• 2013 оны хагас жилийн мал тооллого, түүвэр судалгааны дүн мэдээг нэгтгэн хүлээн авсан.• 2012 онд МЭД-д даатгуулсан малчдад олгох нөхөн төлбөрийн тооцооллыг төслийн програм хангамж ашиглан хийсэн.• Орон нутаг дахь даатгалын компаниудын борлуулалтын мэдээллийн санг битүүмжлэн програм хангамжийг хаасан.• МЭД-ын хураамжийн орлогыг татан төвлөрүүлж эхэлсэн.
8-р сар	<ul style="list-style-type: none">• МЭД-ын 2013 оны борлуулалтын улирлыг хаасан.• 2012 онд МЭД-д хамрагдсан малчдад даатгалын гэрээний дагуу олговол зохих нөхөн төлбөрийг Хаан банкаар дамжуулан олгож эхэлсэн.• Аймгуудын борлуулалтын мэдээллийн санг татсан.
9-10-р сар	<ul style="list-style-type: none">• 2012 онд МЭД-д хамрагдсан малчдад даатгалын гэрээний дагуу олговол зохих нөхөн төлбөрийг Хаан банкаар дамжуулан 100 хувь олгож дууссан.• Оролцогч даатгалын компаниудтай МЭД-ын 2013 оны борлуулалтыг тулгах, МИД-д оролцогчийн хураамжийн бодит хэмжээг тодорхойлох ажил явагдаж байна.



II. МЭД-ын 2013 оны борлуулалт

2.1 МЭД-ын борлуулалтын үр дүн

МИД-ын найм дахь борлуулалтын улирал 2013 оны 4-р сарын 01-нд 21 аймгийн нийт 330 сум, Улаанбаатар хотын 9 дүүрэгт эхэлснээс хойш 2013 оны 6-р сарын 30 хүртэлх хугацаанд төсөлд оролцогч Бодь, Монгол, Монре, МИГ, Номин, Практикал, Тэнгэр даатгалын компаниуд нийт **19,445 малчинтай** Малын эрсдэлийн даатгал /МЭД/-ын гэрээг байгуулж, **1.8 тэрбум төгрөгийн** борлуулалт хийж, **1.2 тэрбум төгрөгийг** МДНТД-нд төвлөрүүлсэн байна. Энэ нь өнгөрсөн 2012 оны МЭД-ын борлуулалттай харьцуулахад борлуулалтын орлого 302.4 сая төгрөг буюу 20.2 хувиар, даатгуулагчдын тоо 3,459 малчин буюу 21.6 хувиар өссөн дүнтэй байна. 2013 оны борлуулалтын улиралд 7 даатгалын компанийн нийт 2,252 даатгалын төлөөлөгч эрх авснаас 1097 төлөөлөгч борлуулалт хийж, нийт малчин өрхийн 13.6 хувийг даатгалд хамруулсан байна.

МЭД-ын нийт хураамжийн орлого нь ДНБ-ний 0.01 хувийг, даатгалын салбарын нийт даатгалын хураамжийн 2.3 хувийг эзэлж байна.

Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо, хураамжийн орлогыг 2006 оноос хойш харахад тогтмол өсч, өссөн дүнгээр нийт 70 мянга орчим малчин өрх даатгалд хамрагдсан байна. График 1 ба 2-т даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, хураамжийн орлогын өсөлтийг харуулав.

График №1. МИД-ын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо¹



¹ 2006-2009 онд даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, борлуулалтын орлогыг авахдаа ҮДБ болон ГХБ-д хамрагдсан малчин өрхийн тоо, ҮДБ ГХБ-ний нийт орлогоор авсан болно.

График №2. МИД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого /сая төгрөгөөр/²

2013 оны нийт хураамжийн орлого, даатгуулсан малчин өрхийн тоог Хүснэгт 2-оос харахад газар зүйн байршил, эрсдэлийн түвшин, малчин өрхийн тооноосоо хамааран харилцан адилгүй хамрагдсан бөгөөд баруун аймгийн нутгаар даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо харьцангуй өндөр байна.

Хүснэгт №2. МЭД-д даатгуулсан малчин өрхийн тоо, даатгуулсан малын нийт үнэлгээ, хураамжийн хэмжээ /2013 он/


№	Аймаг	МИД-д даатгуулсан малчин өрх	Даатгуулсан малын нийт үнэлгээ	Малчны төлсөн хураамжийн хэмжээ
1	Архангай	2,896	3,296,763,617₮	151,374,333₮
2	Баян-Өлгий	514	1,968,867,814₮	40,777,588₮
3	Баянхонгор	3,603	5,845,514,827₮	385,732,242₮
4	Булган	469	1,436,888,138₮	45,676,360₮
5	Говь-Алтай	1,332	2,530,038,912₮	139,444,470₮
6	Говьсүмбэр	116	489,221,296₮	15,209,665₮
7	Дархан-Уул	60	455,520,712₮	9,658,548₮
8	Дорноговь	804	3,818,161,117₮	86,100,590₮
9	Дорнод	571	2,688,841,467₮	64,608,073₮
10	Дундговь	353	1,391,096,655₮	66,793,469₮
11	Завхан	1,334	1,844,671,658₮	103,467,799₮
12	Орхон	80	149,938,135₮	5,480,375₮
13	Өвөрхангай	549	689,586,848₮	36,353,278₮
14	Өмнөговь	664	2,500,190,051₮	72,742,611₮
15	Сүхбаатар	635	2,749,425,050₮	106,887,000₮
16	Сэлэнгэ	423	741,992,256₮	18,492,547₮
17	Төв	720	1,686,240,888₮	60,637,582₮
18	Увс	2,646	4,562,780,745₮	225,421,018₮
19	Улаанбаатар	3	1,148,612₮	60,000₮
20	Ховд	485	2,236,465,051₮	65,497,901₮
21	Хөвсгөл	380	610,321,416₮	19,539,658₮
22	Хэнтий	808	2,511,060,946₮	79,013,489₮
	Нийт	19,445	44,204,736,210	1,798,968,598

² 2006-2009 онд даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, борлуулалтын орлогыг авахдаа ҮДБ болон ГХБ-д хамрагдсан малчин өрхийн тоо, ҮДБ ГХБ-ний нийт орлогоор авсан болно.



2013 оны байдлаар 21 аймагт нийт 144,512 малчин өрх байгаагаас 19,445 өрх буюу 13,5 хувь нь МЭД-д сайн дураараа хамрагджээ. Даатгалд хамрагдсан байдлыг харахад Баянхонгор аймагт хамгийн олон буюу 3,603 малчин өрх малаа даатгуулсан нь аймгийн нийт малчин өрхийн 34,5 хувийг эзэлж байна. /График№3/ Мөн хураамжийн дүнгээр хамгийн их буюу 385,7 сая төгрөгийн хураамжийг Баянхонгор аймгийн малчид төлсөн нь нийт хураамжийн орлогын 21,4 хувийг бүрдүүлж байна. 2006 онд хамрагдсан Баянхонгор, Увс, Хэнтий аймгуудад даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо бусад аймгуудтай харьцуулахад өндөр байгаа нь малчид энэхүү бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой, олон жил даатгуулаад хэвшсэн байгааг харуулж байна.

График №3. Аймгийн малчин өрхөд МЭД-д даатгуулсан малчин өрхийн эзлэх хувь



Хүснэгт №3. МЭД-д хамрагдсан малын тоо(малын төрөл, аймгаар)

№	Аймгийн нэр	Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	Нийт
1	Архангай	317955	121719	59091	34640	321	533726
2	Баян-Өлгий	33644	34113	3173	1977	157	73064
3	Баянхонгор	120206	457634	28459	7996	329	614624
4	Булган	34990	19509	9909	3314	39	67761
5	Говь-Алтай	51561	53513	1558	3939	26	110597
6	Говьсүмбэр	44671	174052	1365	1025	367	221480
7	Дархан-Уул	4581	18016	592	480	0	23669
8	Дорноговь	1996	1314	973	163	0	4446
9	Дорнод	23721	96736	8135	2331	420	131343
10	Дундговь	48079	34694	7566	5154	131	95624
11	Завхан	24462	41799	2431	4392	75	73159
12	Орхон	195915	124952	5293	2140	111	328411
13	Өвөрхангай	12495	120350	785	1604	1052	136286
14	Өмнөговь	7188	3410	1333	263	0	12194
15	Сүхбаатар	85107	76116	16797	10219	120	188359
16	Сэлэнгэ	24224	9207	10251	376	0	44058
17	Төв	94428	52265	10401	12378	127	169599
18	Увс	178784	207983	8746	3799	170	399482
19	Улаанбаатар	0	150	31	0	0	181
20	Ховд	8680	8916	5654	719	12	23981
21	Хөвсгөл	35486	43134	1074	740	130	80564
22	Хэнтий	59184	64907	19650	10473	148	154362
	Нийт	1,407,357	1,764,489	203,267	108,122	3,735	3,486,970



2013 онд нийт 3,486,970 толгой мал МЭД-д хамрагдсан нь манай улсын нийт 40.9 сая малын 8.5 хувийг эзэлж байна. Даатгалд хамрагдсан малын 40.3 хувийг хонин сүрэг, 50.6 хувийг ямаан сүрэг, 5.8 хувийг үхэр сүрэг, 3.1 хувийг адуун сүрэг, 0.1 хувийг тэмээн сүрэг эзэлж байна. /Хүснэгт №3/ Даатгалд хамрагдаж байгаа малын төрлийг харахад эрсдэлд өртөмтгий байдал болон малын тоогоо харгалзан хонь, ямааг ихэвчлэн даатгалд хамруулж, даатгуулж байгаа тухайн төрөл малынхаа үнэлгээг харьцангуй бага үнэлгээгээр сонгон даатгуулж байна.

2012 онд нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн 93,618 төгрөг байсан бол 2013 онд 92,527 төгрөг болж буурсан байна. Энэ нь даатгалын зах зээлийн үнэлгээ болон хураамжийн хувь нэмэгдсэнтэй холбоотой буурсан төдийгүй малчдын худалдан авах чадвар өнгөрсөн жилийнхээс буурсантай холбоотой байна. Нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүнгээрээ Дундговь аймагт хамгийн өндөр буюу 189,217 төгрөгөөр малаа даатгуулжээ.

Даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалт 1,6 сая төгрөгтэй байгаа нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 200,000 төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалтын тоо, хураамжийн орлого болон нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн (2013 он, аймгаар)

№	Аймгийн нэр	Борлуулалт хийсэн даатгалын төлөөлөгчдийн тоо	Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалтын тоо	Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж хураамжийн орлого /төгрөгөөр/	Нэг малчны төлсөн дундаж хураамж /төгрөгөөр/
1	Архангай	118	25	1,282,833	52,270
2	Баян-Өлгий	30	17	1,359,359	79,340
3	Баянхонгор	138	26	2,795,163	107,059
4	Булган	36	13	1,268,787	97,391
5	Говь-Алтай	83	16	1,680,278	104,702
6	Говьсүмбэр	8	15	1,901,208	131,118
7	Дархан-Уул	11	5	878,050	160,976
8	Дорноговь	37	22	2,327,267	107,101
9	Дорнод	37	15	1,746,164	113,149
10	Дундговь	44	8	1,518,033	189,217
11	Завхан	112	12	923,820	77,562
12	Орхон	7	11	782,911	68,505
13	Өвөрхангай	47	12	773,686	66,235
14	Өмнөговь	41	16	1,774,210	109,552
15	Сүхбаатар	52	12	2,055,711	168,342
16	Сэлэнгэ	21	20	880,597	43,718
17	Төв	64	11	948,400	84,219
18	Увс	72	37	3,130,848	85,193
19	Ховд	52	9	1,259,552	135,047
20	Хөвсгөл	25	15	788,522	51,420
21	Хэнтий	60	13	1,316,778	97,789
	Нийт	1096	18	1,641,591	92,527



2.2 МЭД-ын бүлгийн даатгал

2013 оны борлуулалтын улиралд шинээр малчдын бүлгийн малыг даатгах МЭД-ын бүлгийн даатгалын бүтээгдэхүүнийг Завхан аймгийн Цагаанчулуут, Цагаанхайрхан, Идэр, Тэлмэн, Нөмрөг, Цэцэн-Уул сумдад Ногоон алт хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан малчдын бүлэгт туршин хэрэгжүүллээ. ТХН-йн зүгээс холбогдох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан юм.

Нийт Завхан аймгийн 6 суманд хэрэгжсэн МЭД-ын бүлгийн даатгалд Цагаанхайрхан сумын нийт 80 малчин өрх бүхий 4 бүлэг 38,1 сая төгрөгөөр малаа үнэлж 2 сая төгрөгөөр малаа даатгууллаа. Энэ нь тухайн 6 суманд байгаа 64 малчдын бүлгийн 6.3 хувийг эзэлж байна. Нийт 11,252 мал даатгуулснаас 7,443 хонь, 3,382 ямаа, 252 үхэр, 175 адуу даатгуулсан байна. Малчдын бүлгийн дундын санд малаа даатгуулах хөрөнгө мөнгө тусгагдаагүй, даатгуулах шийдвэрийг бүлгийн хурлаар шийддэг бөгөөд бүлгийн гишүүд даатгалын талаарх мэдлэг дутмаг, зарим бүлгийн малчид МЭД-д малаа даатгуулсан тул дахин бүлэгт даатгуулах сонирхол байгаагүй зэрэг шалтгаануудаас үүдэн даатгалд цөөн малчид хамрагдсан нь ажиглагдсан юм.

2.3 Өмгөлттэй зээл

Даатгуулах хүсэлтэй боловч бэлэн мөнгөгүй байгаа малчдыг бичил зээлийн тусламжтайгаар малаа даатгуулах боломжийг олгох зорилготой даатгалын хураамжийн зээлийг ХААН банкнаас жил бүр олгодог. ТХН-ээс Хаан банктай хамтран 2013 оны 4 дугаар сарын 1-ээс 6 дугаар сарын 30-ны хооронд 21 аймгийн нийт 330 сумдын Хаан банкны орон нутгийн салбаруудаар дамжуулан МЭД-ын хураамжийн зээлийг санал болгож, 8 аймгийн нийт 48 малчинд 10,831,315.00 төгрөгийн хураамжийн зээлийг олголоо.

Түгээгдээгүй №5. Өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр, өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр

№/А	Сум	Өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр, өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр	Өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр, өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр	Өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр, өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр	Өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр, өмгөлттэй зээл олгогчийн үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр
1	Цагаанхайрхан	1	400,000	266,666.67	133,333.33
2	Идэр	2	619,571	413,047.33	206,523.67
3	Нөмрөг	11	2,439,820	1,626,546.67	813,273.33
4	Цэцэн-Уул	2	252,880	168,586.67	84,293.33
5	Тэлмэн	16	3,409,200	2,272,800.00	1,136,400.00
6	Цагаанчулуут	7	1,507,700	1,005,133.33	502,566.67
7	Өмгөлттэй зээл	1	292,000	194,666.67	97,333.33
8	Ногоон алт	8	1,910,144	1,273,429.33	636,714.67
Бүгд		48	10,831,315.00	7,220,876.67	3,610,438.33



Хүснэгт №6. 2013 оны хөнгөлөлттэй зээлийн хэмжээ болон зээлдэгчийн тоо
/2013 оны 8-р сар хүртэл/

№	Аймаг	2013 оны Нийт олголт	
		Зээлдэгчийн тоо	Зээлийн хэмжээ
1	Баянхонгор	438	1,191,686,000₮
2	Сүхбаатар	122	506,300,000₮
3	Увс	92	206,000,000₮
4	Хэнтий	192	825,000,000₮
5	Говь-Алтай	1	2,000,000₮
6	Сэлэнгэ	10	40,100,000₮
7	Ховд	2	4,000,000₮
8	Дорнод	13	58,605,000₮
9	Хөвсгөл	1	5,000,000₮
10	Дундговь	34	141,200,000₮
11	Дорноговь	87	373,708,000₮
12	Архангай	52	137,150,000₮
13	Говьсүмбэр	1	3,000,000₮
Нийт		1045	3,493,749,000₮

Мөн Хаан Банкны зүгээс МЭД-д хамрагдсан малчдад малчдын зээлийн хөнгөлөлт /сарыг хүү нь тухайн орон нутгийн малчны зээлийн хүүгээс 0.2 функтээр бага/-ийг үзүүлж байгаа билээ. Өнгөрсөн 8 жилийн туршид нийт 4230 орчим малчин 10.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, 245.3 сая төгрөгийн зээлийн хөнгөлөлт эдлээд байна.

Төгрөгөөр хэмжээгээр хөнгөлөлттэй зээлийн хэмжээ болон хөнгөлөлтийн хэмжээний өөрчлөлт /2006-2013 он/



ТХН-ийн зүгээс Хаан банк болон бусад арилжааны банктай цаашид хамтран ажиллах сонирхол өндөр байгаа. Иймд Төрийн банкинд хүсэлт гаргасны үр дүнд МЭД-д хамрагдсан малчдад Малчны зээлийн хөнгөлөлт /сарын хүүг 0.2%-иар бууруулах/ үзүүлэх Хамтын ажиллагааны гэрээг 2013 оны 9-р сард байгуулан ажиллаж байна. Мөн түүнчлэн арилжааны банкаар дамжуулан МЭД-ын бүтээгдэхүүнийг малчдад хүргэх, банк болон даатгалын хамтарсан шинэ бүтээгдэхүүн гаргах талаар судалж байна.



III. Даатгалын компани

Даатгалын компаниудын борлуулалтын үр дүнг авч үзвэл нийт 19,445 малчин өрхийг даатгалд хамруулснаас 29.9 хувийг “Монгол даатгал” ХХК, 25.2 хувийг “Бодь даатгал” ХХК, 19.9 хувийг “Тэнгэр даатгал” ХХК, 16.8 хувийг “Практикал даатгал ХХК, 6.2 хувийг “МИГ даатгал” ХХК, 1.5 хувийг “Монре даатгал” ХХК, 0.5 хувийг “Номин даатгал” ХХК-иуд тус тус эзэлжээ. МИД төсөлд шинээр оролцож буй МИГ даатгал, Монре даатгал, Номин даатгал компаниудын хувьд борлуулалтын 8.2 хувийг эзэлж байна.


Хүснэгт №7. Даатгалын компаниудын борлуулалтын тоо (аймгаар, 2013 он)

№	Аймгийн нэр	Монгол	Бодь	Тэнгэр	Практикал	Монре	Номин	МИГ	Нийт
1	Архангай	610	565	724	437			560	2,896
2	Баян-Өлгий	167	243	54	50				514
3	Баянхонгор	1,098	1,001	708	602		60	134	3,603
4	Булган	186	213	1	69				469
5	Говь-Алтай	468	346	259	195			64	1,332
6	Говьсүмбэр	116							116
7	Дархан-Уул	27	19		8	6			60
8	Дорноговь	193	425		186				804
9	Дорнод	91	115	209	156				571
10	Дундговь	251	67		12	23			353
11	Завхан	365	290	454	98			127	1,334
12	Орхон	11	17		31	21			80
13	Өвөрхангай	179	57	98	179		15	21	549
14	Өмнөговь	535	33		96				664
15	Сүхбаатар	294	130	137	74				635
16	Сэлэнгэ	187	231		5				423
17	Төв	105	137		349		24	105	720
18	Увс	623	552	544	541	234		152	2,646
19	Улаанбаатар				3				3
20	Ховд	118	92	199	66	10			485
21	Хөвсгөл	45	221	72	9			33	380
22	Хэнтий	148	142	410	108				808
	Нийт	5,817	4,896	3,869	3,274	294	99	1,196	19,445

2013 оны борлуулалтаар нийт 1.8 тэрбум төгрөгний борлуулалт хийсний 33.8 хувийг Монгол даатгал, 26.6 хувийг Бодь даатгал, 18.0 хувийг Тэнгэр даатгал, 14.8 хувийг Практикал даатгал, 1.3 хувийг Монре даатгал компани тус тус эзэлж байгаа бол шинээр төсөлд орсон МИГ даатгал компани 4,9 хувийг, Номин даатгал компаний 0,6 хувийг тус тус эзэлжээ. МИД-ын 2013 оны борлуулалтын орлогын хэмжээг оролцогч даатгалын компани тус бүрээр харуулбал:



График №5. Даатгалын компаниудын хураамжийн орлого, дүнд эзлэх хувиар



Хүснэгт №8. Даатгалын компаниудын МЭД-ын хураамжийн орлого (сая төгрөгөөр, 2013 он)

№	Аймгийн нэр	Монгол	Бодь	Тэнгэр	Практикал	Монре	Номин	МИГ	Нийт
1	Архангай	37.96	29.55	34.98	18.45	-	-	30.43	151.37
2	Баян-Өлгий	10.55	21.62	4.41	4.20	-	-	-	40.78
3	Баянхонгор	108.18	128.35	64.96	65.89	-	4.73	13.62	385.73
4	Булган	17.93	19.40	0.37	7.97	-	-	-	45.68
5	Говь-Алтай	46.71	36.83	36.01	12.00	-	-	7.89	139.44
6	Говьсүмбэр	15.21	-	-	-	-	-	-	15.21
7	Дархан-Уул	3.77	4.25	-	1.01	0.63	-	-	9.66
8	Дорноговь	24.03	47.51	-	14.56	-	-	-	86.10
9	Дорнод	12.92	13.81	22.12	15.75	-	-	-	64.61
10	Дундговь	49.63	10.68	-	2.74	3.74	-	-	66.79
11	Завхан	26.96	27.11	31.13	10.13	-	-	8.14	103.47
12	Орхон	0.87	1.76	-	1.96	0.89	-	-	5.48
13	Өвөрхангай	12.45	4.77	6.86	9.31	-	1.28	1.68	36.35
14	Өмнөговь	64.23	1.75	-	6.76	-	-	-	72.74
15	Сүхбаатар	57.21	25.92	13.52	10.24	-	-	-	106.89
16	Сэлэнгэ	8.21	9.84	-	0.44	-	-	-	18.49
17	Төв	9.52	11.59	-	23.94	-	4.63	10.95	60.64
18	Увс	62.41	42.14	51.01	40.57	16.34	-	12.95	225.42
19	Улаанбаатар	-	-	-	0.06	-	-	-	0.06
20	Ховд	16.87	16.07	22.01	9.26	1.29	-	-	65.50
21	Хөвсгөл	3.54	7.01	6.23	0.71	-	-	2.04	19.54
22	Хэнтий	18.78	18.79	31.04	10.41	-	-	-	79.01
	Нийт	607.93	478.78	324.65	266.37	22.89	10.64	87.70	1,798.97




Өнгөрсөн оны борлуулалттай харьцуулахад даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо 21.6 хувь, хураамжийн орлого 20.2 хувиар өсч, Монгол даатгал, Тэнгэр даатгал компаниудын даатгуулагчийн тоо хураамжийн орлого буурч, Бодь даатгал, Практикал даатгал компаниудынх өссөн байна. Харин Монре даатгал компанийн даатгуулагчийн тоо өссөнч, хураамжийн орлого нь буурсан дүнтэй байна.

Хүснэгт №9. Даатгуулагчдын тоо ба хураамжийн орлогын 2012 оны борлуулалттай харьцуулсан дүн (даатгалын компаниар)

№	Компани	Даатгасан малчин өрх	2012 оны борлуулалт	Өсөлтийн хувь	Хураамжийн орлого	2012 оны борлуулалт	Өсөлтийн хувь
1	Монгол даатгал	5817	6142	-5.29%	607,927,898₮	626,386,079₮	-2.9%
2	Бодь даатгал	4896	3228	51.67%	478,780,098₮	325,154,713₮	47.2%
3	Тэнгэр даатгал	3869	4065	-4.82%	324,653,783₮	339,654,397₮	-4.4%
4	Практикал даатгал	3274	2305	42.04%	266,369,426₮	181,767,656₮	46.5%
5	Монре даатгал	294	248	18.55%	22,891,958₮	23,790,282₮	-3.8%
6	Номин даатгал	99			10,643,784₮		
7	МИГ даатгал	1196			87,701,651₮		
Нийт		19445	15988	21.62%	1,798,968,598₮	1,496,753,128₮	20.2%

2013 оны борлуулалтын улиралд нийт 2,252 даатгалын төлөөлөгч МЭД-ыг борлуулах эрх авснаас нийт 1096 төлөөлөгч /Бодь Даатгал компани 260, Монгол Даатгал компани 324, Тэнгэр Даатгал компани 172, Практикал Даатгал компани 228, Монре даатгал 25, Номин даатгал компани 10, МИГ даатгал компани 77/ борлуулалт хийж үр бүтээлтэй ажилласан бол 1155 даатгалын төлөөлөгч борлуулалт хийгээгүй байна.

График №6. Борлуулалт хийсэн болон борлуулалт хийгээгүй даатгалын төлөөлөгчдийн тоо (даатгалын компаниар)





Дүгнэлт

2013 оны МЭД-ын борлуулалтын тайланг борлуулалтын улиралд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, борлуулалтын үр дүн, даатгалын компаниудын борлуулалтын үр дүнг тусган харууллаа. 2013 оны борлуулалтын улирлаар нийт 1,8 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 1,2 тэрбум төгрөгийг Малын даатгалын нөхөн төлбөрийн дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь өнгөрсөн 2012 оны МЭД-ын борлуулалттай харьцуулахад борлуулалтын орлого 302.4 сая төгрөг буюу 20.2 хувиар, даатгуулагчдын тоо 3,459 малчин буюу 21.6 хувиар өссөн дүнтэй байна. Хураамжийн орлого, даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо жил бүр тогтмол өсч байгаа нь малчид энэхүү даатгалын бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой, даатгалын компаниуд энэ бүтээгдэхүүнийг борлуулах, тодорхой хэмжээний эрсдэл үүрэх боломжтой байгаа төдийгүй цаашид малын индексжүүлсэн даатгал тогтвортой оршин тогтнохын нэгэн баталгаа болж байна.

Аймгуудын борлуулалтын үр дүнгээс харахад өмнө нь төсөлд хамрагдаж байсан аймгуудын хувьд малчид нь МИД төслийн талаар өргөн мэдээлэлтэй төдийгүй малын даатгалын үр шимийг хүртсэн, тэр хэмжээгээрээ ач холбогдлыг ойлгодог болсон бол төсөлд хамрагдаад удаагүй байгаа аймгуудын малчид МИД төслийн талаар мэдээлэл бага, малын даатгалд итгэх итгэл муутай байгаа нь борлуулалтын үр дүнгээс харагдаж байна. Мөн шинэ аймгуудад даатгалын компанийн салбар нэгжийн тоо цөөн, боловсон хүчин болон даатгалын төлөөлөгчийн чадвар дутмаг байгаа нь борлуулалтын явцад харагдаж байсан. Мөн малчдын хамрагдалтыг харахад цаг агаарын байдал, малчин өрх, малын тооноосоо хамааран харилцан адилгүй хамрагдаж байгаа бөгөөд ихэвчлэн баруун аймгуудын нутгаар хамрагдалт өндөр байна.

Даатгалын компаниудын борлуулалтын үр дүн болон нийт борлуулалтанд эзлэх хувийг харахад төсөлд оролцож байгаа хуучин компаниуд болох Бодь даатгал, Монгол Даатгал, Практикал даатгал, Тэнгэр даатгал компаниуд нийт борлуулалтын 92 хувийг эзэлж байна. Энэ нь тухайн даатгалын компанийн салбар нэгжийн тоо, тэдгээрийн харьяалагдах аймгийн эрсдэлийн түвшин, мөн даатгалын төлөөлөгчдийн ажил мэргэжил, ажлын туршлага, идэвх санаачлага, сум орон нутгийн удирдлагын оролцоо зэргээс хамааран харилцан адилгүй байгаа төдийгүй малчид анх даатгуулсан компани, төлөөлөгчдөд давтан даатгуулж байгаа нь харагдсан юм. Иймд шинээр нэмэгдэж байгаа даатгалын компанийн салбарууд болон төлөөлөгчдийг чадавхижуулах асуудал чухал байна.

Хэдийгээр даатгуулсан малчин өрхийн тоо нэмэгдсэн ч нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн 92,517 төгрөг болж бага хэмжээгээр буурсан нь даатгалын зах зээлийн үнэлгээ болон хураамжийн хувь нэмэгдсэнтэй холбоотой төдийгүй малчдын худалдан авах чадвар өнгөрсөн жилийнхээс буурсантай холбоотой байна.

Нийт 3,491,171 толгой мал МЭД-д хамрагдсан нь манай улсын нийт 40.9 сая малын 8.5 хувийг эзэлж байна. Даатгалд хамрагдаж байгаа малын төрлийг харахад эрсдэлд өртөмтгий байдал болон малын тоогоо харгалзан хонь, ямааг ихэвчлэн даатгалд хамруулж, даатгуулж байгаа тухайн төрөл малынхаа үнэлгээг харьцангуй бага үнэлгээгээр сонгон даатгуулж байна.

2013 оны борлуулалтын улиралд шинээр малчдын бүлгийн малыг даатгах МЭД-ын бүлгийн даатгалын бүтээгдэхүүнийг Завхан аймгийн 6 суманд туршин хэрэгжүүлж, 1



сумын 4 бүлэг /нийт 82 малчин өрх/ даатгалд хамрагдсан байна. Бусад сумдууд нь даатгалд хамрагдахгүй гэсэн шийдвэрийг гаргасан бөгөөд малчдын бүлгийн дундын санд малаа даатгуулах хөрөнгө мөнгө тусгагдаагүй, даатгуулах шийдвэрийг бүлгийн хурлаар шийддэг бөгөөд бүлгийн гишүүд даатгалын талаарх мэдлэг дутмаг, зарим бүлгийн малчид МЭД-д малаа даатгуулсан тул дахин бүлэгт даатгуулах сонирхол байгаагүй зэрэг шалтгаануудаас үүдэн даатгалд цөөн малчид хамрагдсан байна. Энэхүү бүтээгдэхүүнийг цаашид үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд холбогдох судалгаа, сургалтыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байгаа юм.

Малчид Хаан банкнаас зээл авах нь ихсэж байгаа бөгөөд 2013 оны эхний 8 сарын байдлаар нийт 3,5 тэрбум орчим төгрөгний хөнгөлөлттэй зээл олгогдсон байгаа нь өнгөрсөн 2012 оны нийт хөнгөлөлттэй зээлийн хэмжээнээс 1,4 тэрбум төгрөгөөр их төдийгүй зээлийн хөнгөлөлт нь 70.5%-аар өссөн байна. Иймд цаашид малчдад үзүүлэх хөнгөлөлтийг улам нэмэгдүүлэх, орон нутагт зээл олгож байгаа өөр арилжааны банкуудаар дамжуулан малчдад зээлийн хөнгөлөлтийг үзүүлэх зорилгоор Төрийн банктай 2013 оны 9 сараас эхлэн гэрээ байгуулан ажиллаж байна.